



Үнэлгээ гэж юу вэ?

Рэймонд Жервейс

2022



Агуулга

- Нэр томъёоны тодорхойлолт
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний **ялгаа**
- Хяналт-шинжилгээ, үнэлгээний **хоорондын уялдаа холбоо**
- ХШҮ-ний **үе шатууд**
- **Үнэлгээний дизайн** болон **гол асуултуудыг** тайлбарлах
- **ХШҮ төлөвлөгөөнд агуулагдах үнэлгээний бүрдэл хэсгүүдийг** тайлбарлах
- Үнэлгээний үр дүнг үр дүнтэй мэдээлэх
- Сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг **үнэлэх**

Нэр томъёоны тодорхойлолт

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, 2002 :

Хэрэгжиж буй болон дуусгавар болсон төсөл, хөтөлбөр, бодлогын дизайн (арга, аргачлалын хүрээ), хэрэгжилт, үр дүнгийн системчилсэн, объектив үнэлгээг. Уг үнэлгээгээр зорилтуудын харилцан хамаарал, биелэлт, хөгжлийн үр ашиг, үр дүнтэй байдал, нөлөөлөл, тогтвортой байдлыг тодорхойлох зорилготой. Үнэлгээний тоо мэдээлэл нь найдвартай, хэрэглэгдэхүйц байх хэрэгтэй ба хүлээн авагч тал, донор байгууллагын шийдвэр гаргалтад нөлөөлөх сургамж зэргийг тусгана.

Түүнчлэн үнэлгээ нь үйл ажиллагаа, бодлого, хөтөлбөрийн үнэ цэнэ, ач холбогдлыг тодорхойлох үйл явц юм. Төлөвлөсөн, хэрэгжиж буй эсвэл дуусгавар болсон хөгжлийн интервенцийн системчилсэн, объектив үнэлгээ юм.

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”

Байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын хэрэгжилтийг төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхэд дүн шинжилгээ хийж өгсөн үнэлэлтийг

Хяналт-шинжилгээ ба үнэлгээ

	Хяналт-шинжилгээ (monitoring)	Үнэлгээ (evaluation)
Хэрэглээ	Байнгын, тогтмол	Үе шаттайгаар, урьдчилан тодорхойлсон тайлант үеүдэд
Зорилт	Хэрэгжилтийн явцыг хянана	Бодлого, зорилго, зорилт хэрхэн үр дүнд хүрч байгааг тодорхойлно
Арга	Шалгуур үзүүлэлт болон урьдчилан төлөвлөсний дагуу мэдээлэл цуглуулна	Мэдээлэл цуглуулах ахисан түвшний арга ашиглах, үр нөлөөний дүн шинжилгээ хийх
Үр дүн	Явцын хяналт	Стратегийн хяналт
Ерөнхий асуулт	Бид урагшилж байна уу?	Бид зөв зүйл хийж байна уу?
Тодорхойлолт	“ хяналт-шинжилгээ ” гэж байгууллагын үйл ажиллагаа болон бодлогын зорилго, зорилт, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явцыг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хянах, мэдээлэх тасралтгүй үйл ажиллагааг	Үнэлгээ гэж байгууллагын үйл ажиллагаа болон бодлогын зорилго, зорилт, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнг системтэйгээр, объектив байдлаар хийсэн үнэлгээг хэлнэ. Үнэлгээг хэрэгжилтийн дунд шатанд болон төгсгөлд төлөвлөгөөт байдлаар давтамжтай хийдэг.

ХШҮ-ний үе шатууд:

ХШҮ- итгэх олон нийтийн итгэл нь өгөгдлийн чанарын хяналт нээлттэй ил тод тайлагналаас үүдэлтэй.



Эх үүсвэр: Дэлхийн банкны хэвлэл “Үр дүнд хүрэх зам: Хөгжлийн үр ашгийн үнэлгээг боловсруулах, хэрэгжүүлэх нь”. *Монголоор унших боломжтой*

Үнэлгээний онцлог шинж

Үнэлгээ нь дараах онцлог шинжтэй:

- Хэрэглээнд тулгуурлсан – ажил, үйл ажиллагаа
- Практикт хэрэглэгдэхүйц үр дүнг бий болгох
- Оролцогчдод үр ашигтай байх

Үнэлгээгээр хийсэн ажил нь субъектив дүгнэлт биш, харин бодитой, системтэй, нарийн дэс дараатай хийгдсэн байх ёстой.

Үнэлгээний дизайн ба гол асуултууд

Төлөвлөлт

Үнэлгээний асуултууд юу байх вэ? Тэдгээр нь хэрхэн хариулагдах вэ?

Хэрэгжилт

Хариулт авах үр дүнтэй аргачлал юу байх вэ?

Ашиглалт

Зорилготой уялдуулан үр дүнг хэрхэн танилцуулах вэ?

ҮНЭЛГЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨ

Өгөгдөд
цуглуулах

Өгөгдөл
боловсруулах

Өгөгдөлд дүн
шинжилгээ хийх


Өгөгдлийг
тайлбарлах

Аргыг төлөвлөх (судалгааны)
Арга А
Арга В
Арга С

Тайлагнал

Үнэлгээний гол асуултууд

- Үнэлгээний цөм нь үнэлгээний гол асуултууд юм. Үнэлгээний үйл явцын бусад бүх хэсгүүд эдгээр асуултуудаар чиглүүлэгдэж явдаг.
- Үнэлгээний асуултууд нь үнэлгээний хил хязгаар, хамрах хүрээг бүрдүүлдэг бөгөөд үнэлгээ нь юуг анхаарах, юуг анхаарахгүйг бусдад мэдээлэх зорилготой.




Асуултын төрлүүд:

- **Тойм:** Одоогийн төлөв байдал:
- Юу вэ?
- Үр нөлөө болон гарцын үзүүлэлтүүдийн өөрчлөлт
- **Норматив:** харьцуулалт:
- Юу байх ёстой
- Хүлээгдэж буй үр дүн/ зорилт
- Үр нөлөө ба гарцын гүйцэтгэл
- **Шалтгаан ба үр дагавар:**
- Хөтөлбөр өөрчлөлтийн шалтгаан болсон уу?
- Ямар үр нөлөөг хэнд

ЭЗХАХБ-Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд

- ✓ Ач холбогдол/
Relevance
 - Оролцогч талууд болон үр шим хүртэгчдийн хэрэгцээ шаардлага, тэргүүлэх зорилтод нийцсэн байдал
- ✓ Үр дүнтэй/
Effectiveness
 - Хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд зорилтдоо хүрч буй эсэх
- ✓ Үр ашиг/
Efficiency
 - Зарцуулсан нөөц (орц) болон бүтээгдэхүүн үйлчилгээ (гарц) хамаарал
- ✓ Нөлөөлөл/
Impact
 - Үр дүнд гарч буй бүх өөрчлөлтүүд
- ✓ Тогтвортой байдал/
Sustainability
 - Бодлого, төсөл, хөтөлбөр дууссаны дараа ч гарсаар байх үр шим

Мэдээлэл цуглуулах аргууд



Эдгээр аргуудыг хяналт үнэлгээний аль алинд ашиглаж болдог

Оролцогчид ба үнэлгээний дизайн

Төлөвлөлт

Оролцогч талуудын шинжилгээ

Үнэлгээний зорилго юу вэ? Ямар нэгэн нэмэлт даалгавар бий юу?(өөр сонирхол)

Хэрэгжилт

Оролцогч талуудын оролцоо

Үнэлгээний үр дүнг ашиглах, сайжруулахад оролцогч талуудыг хэрхэн татан оролцуулж, тэдний мэдлэг, туршлагыг дайчлах вэ?

Ашиглалт

Оролцогч талуудын хариу үйлдэл

Оролцогч талууд үнэлгээг хүлээн зөвшөөрөх, гарсан үр дүнг ашиглах байдлыг хэрхэн идэвхжүүлэн өдөөх вэ?

ХШҮ- төлөвлөгөөн дэх үнэлгээний бүрдэл хэсгүүд

- Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөлтийн үнэлгээний бүрэлдэхүүн хэсэгт дараахь зүйлийг тусгах хэрэгтэй:
- **Үндэслэл, зорилго:** Үнэлгээг яагаад хийж байна вэ? Яагаад яг энэ цаг үед? Энэ нь хэний төлөө хийгдэж байна вэ? Үүнийг суралцах, тайлагнах эсвэл өөр зорилгоор ашиглах уу?
- **Тодорхой зорилтууд:** Үнэлгээгээр юуг олж мэдэхийг зорьж байна вэ?
- **Урьдчилсан гол асуултууд:** Шинэ төслийн дизайны үе шатанд оролцогч талуудын сонирхсон үнэлгээний гол асуултуудыг аль хэдийн тодорхойлох боломжтой байж болно. Жишээ нь: хэрэв төсөл нь шинэлэг арга барилыг хэрэгжүүлж байгаа бол ямар элементүүдийг, хэзээ үнэлэхийг хүсч байна вэ? Энэ нь хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн хэрэгцээг тодорхойлж, мэдээллийг цаг тухайд нь цуглуулах боломжийг олгодог.
- **Хамрах хүрээ:** Юуг үнэлж байна вэ? Энэ нь төслийн тодорхой бүрэлдэхүүн хэсэг, тодорхой газарзүйн бүсэд явагдаж буй үйл ажиллагаа эсвэл өөр зүйл үү?
- **Хугацаа:** Үнэлгээг хэзээ хийх вэ? Үнэлгээний үр дүн хэзээ бэлэн болох вэ?

ХШҮ- төлөвлөгөөн дэх үнэлгээний бүрдэл хэсгүүд (үргэлжлэл)


- **Хариуцлага:** Үнэлгээг хэн удирдах вэ? Үүнийг хэрхэн зохицуулах вэ?
- **Төсөв:** Энэ үнэлгээг ахлан удирдах эсвэл оролцоход хэр их зардал гарах вэ?
- ГХХ бүрэн хэрэгжүүлнэ гэвэл, хэдэн жилийн дараа гүйцэтгэлийг үнэлэхийн тулд одоо юу хийх ёстой вэ?
- **Өмнөх үнэлгээ:** Төсөл болон түүний үнэлгээг илүү сайн төлөвлөхөд тань тусалж чадах ижил төстэй төслүүд, ялангуяа өмнөх үе шатанд хийсэн үнэлгээнүүд байгаа юу?
- **Үнэлэгдэхүйц байдал:** Үнэлэгдэхүйц байдлыг тодорхойлох шаардлагатай юу?
 - Хөтөлбөрийн дизайн, логик загвар ба/эсвэл өөрчлөлтийн онолыг дахин шалгах
 - Хөтөлбөрийн гүйцэтгэлийг хэмжих хүрээ, хяналт-шинжилгээний системийг үнэлдэг
 - Хяналт ба өгөгдөл, суурь үзүүлэлтийн найдвартай байдал, ашигтай байдлыг нарийн шалгаж баталгаажуулдаг.
 - Төлөвлөсөн үнэлгээний хэрэгцээг нягтална

Үнэлгээний үр дүнг үр дүнтэй мэдээлэх

- Үнэлгээний эцсийн тайлан нь үр дүнг зорилтот хүмүүст хүргэхэд хангалтгүй юм.
- Харилцаа холбооны төлөвлөгөөтэй байх ёстой
- Үр дүнтэй мэдээллэх, үр дүнг түгээхэд харилцаа холбооны хэд хэдэн сувгууд болон бүтээгдэхүүн шаардлагатай.
- Үр дүнтэй тайлан гаргахын тулд дараах бүрэлдэхүүн хэсгүүдийг санал болгож байна.
 - Товч хураангуй
 - Оршил
 - Үнэлгээний арга, аргачлал
 - Үнэлгээний үр дүн
 - Дүгнэлт
 - Зөвлөмж

Үйл ажиллагааны төлөвлөгөө

Хөтөлбөрийн үнэлгээний хамгийн чухал ашиг тусын нэг бол сайжруулалт хийх хэрэгцээг тодорхойлдог юм.



“ Баярлалаа “





Mongolia:
Enhancing Resource
Management through
Institutional Transformation

Address: Floor 3, National Times News Tower Khudaldaanii gudamj, Khoroo 1
Chingeltei district, Ulaanbaatar-15160 Mongolia

Phone: 7610-5000